

Алтны дараагийн хөдөлгөөн юу байх вэ? Жо ДиНаполи EBC Санхүүгийн Групп-тэй хамтран 2025 оны төлөвийг хуваалцлаа

Өсөлтийн хандлагатай ч хэлбэлзэл өндөр; \$10,000 хүрэх магадлал бага

BANGKOK, THAILAND, May 20, 2025 /EINPresswire.com/ -- Эдийн засгийн тодорхойгүй байдал, худалдааны хурцадмал байдал, дэлхий нийтийн геополитикийн шилжилтийн дунд дэлхийн хөрөнгө оруулагчид алт руу дахин анхаарлаа хандуулж, үүнийг найдвартай хамгаалалт гэж үзэж байна. 2025 оны 5-р сарын 7-нд Fintrade Club [EBC](#) Санхүүгийн Групп-тэй хамтран “2025 оны алтны чиг хандлагыг DiNapoli аргачлалаар задлан шинжлэх нь” сэдвийн дор онцгой семинар зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд алдарт техник шинжээч, Fibonacci суурьт стратегиараа алдартай, “DiNapoli Levels”-ийн бүтээгч Жо ДиНаполи оролцож, 2025 оны алтны төлөв байдлын талаар онцгой хуваалтыг хийсэн юм.



Жо ДиНаполи болон Мончай Конгтанафакди нар Fintrade Club болон EBC Санхүүгийн Группийн хамтран зохион байгуулсан Бангкок дахь алтны зах зээлийн төлөвийн семинарын үеэр оролцогчидтой уулзаж, санал солилцов.

DiNapoli аргыг тогтворгүй зах зээлд ашиглах

Өргөн цар хүрээтэй илтгэл, шууд ярилцлагын үеэр Жо ДиНаполи өөрийн өвөрмөц техник аргачлалаар дэлхийн макро эдийн засгийн дарамтуудыг тайлбарлан, 2025 оны алтны зах зээлийн төлөвийн талаар үзэл бодлоо хуваалцлаа. Түүнтэй хамт Тайланд дахь DiNapoli арга зүйн тэргүүлэх мэргэжилтэн Мончай Конгтанафакди оролцож, оролцогчдод жилийн, улирлын, өдрийн графикуудад суурилсан цаг хугацааны үндэслэлтэй DiNapoli түвшнүүдийг ашиглан алтны боломжит хөдөлгөөнийг нарийвчлан задлан шинжлэх боломжийг олгов.

ДиНаполи алтыг “аюулгүй хөрөнгө” хэвээр байгааг онцолж, дэлхий дахинд өсөн нэмэгдэж буй эрсдэлүүдийн дунд байр сууриа хадгалж байгааг дурдав. Тэрээр Орос-Украины мөргөлдөөн үргэлжилсээр буй байдал, Өмнөд Азид нэмэгдэж буй хурцадмал байдал, АНУ-

ын санхүүгийн тогтворгүй байдал зэрэг хямралуудын давхцлыг алтны өсөлтийн хандлагыг дэмжигч гол хүчин зүйлс гэж нэрлэлээ. Жил бүр их наядаар хэмжигдэх болсон АНУ-ын төсвийн алдагдлын улмаас долларын ноёрхлыг удаан хадгалах боломжийн талаар тэрээр эргэлзэж буйгаа илэрхийлээд, алт нь үнэ цэнээ хадгалах найдвартай хэрэгсэл хэвээр байгааг онцолсон юм.

Техникийн дүн шинжилгээ: Богино хугацааны хэлбэлзэл, урт хугацааны бат бөх хандлага

Алтны зах зээлийн урт хугацааны өсөлтийн чиг хандлагыг бататгасан Жо ДиНаполи, ойрын хугацаанд алтны үнэ өндөр хэлбэлзэлтэй байхыг анхаарууллаа. Тэрээр өдөр тутмын үнийн савлагаа унц тутамд 500 ам.долларт хүрч

магадгүй гэж таамаглаж байна. Хятадын юань, Японы иен, эсвэл дижитал валют зэрэг өөр хөрөнгө рүү хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэж байгаа ч, тэрээр өөрийн байр суурийг дахин бататгав: “Алтаас илүү найдвартай газар гэж үгүй.”

Гэсэн ч ДиНаполи алтны үнийн хэт өсөлттэй холбоотой хүлээлтэд болгоомжтой хандахыг анхааруулсан. Алт тогтвортой өсөх магадлалд итгэлтэй байгаа ч, унц \$10,000 хүрэх боломжийг ердөө 10% гэж үнэлж, зах зээл дээрх хэт өөдрөг төсөөллөөс ялгавартай байр суурь илэрхийлэв. Харин тэрээр \$3,720–\$4,200 хоорондын үнийн түвшинг дунд хугацааны гол эсэргүүцлийн бүс гэж тодорхойлон, арилжаачдад зах зээлийг дахин орохоос өмнө үнийн ухралтыг хүлээхийг зөвлөлөө.

Сүүлийн хэдэн жилд анх удаа хөрөнгийн зах зээлд бууралт хүлээж эхэллээ

Семинарын үеэр зах зээлийн өргөн хүрээний чиг хандлагын талаар мөн хэлэлцлээ. Жо ДиНаполи дэлхийн хөрөнгийн зах зээлд богино (short) байр суурь барьж эхэлсэн тухайгаа мэдэгдсэн нь түүний хөрөнгө оруулалтын стратегид гарч буй томоохон өөрчлөлт юм. Энэ нь сүүлийн хэдэн жилийн хугацаанд түүнийг анх удаа хөрөнгийн зах зээлийн бууралтад байр суурь илэрхийлж буй тохиолдол бөгөөд анхаарал татаж байна. Тайландын хөрөнгийн биржийн хувьд тодорхой дүн шинжилгээ хийхээс татгалзсан ч, түүний үзэж буйгаар тус зах зээл нь дэлхийн нийт чиг хандлагыг дагах хандлагатай байх магадлалтай гэжээ.

Арилжаачдын хамтын нийгэмлэгтэй харилцах нь

Семинарын дараа Жо ДиНаполи болон Мончай Конгтанафакди нар хэвлэл мэдээлэл болон гол нөлөөлөгчдийг (KOLs) оролцуулсан тусгай уулзалтад оролцож, семинарын үеэр хэлэлцсэн арилжааны аргачлал, зах зээлийн нөлөөллийн талаар илүү гүнзгий ярилцах боломж олгов.

Эцэст нь хүрсэн гол мессеж: тодорхойгүй цаг үед системтэй шинжилгээ, сахилга баттай стратеги хамгийн чухал

Эдийн засгийн тодорхойгүй, хэлбэлзэл өндөртэй орчинд зах зээлийг ойлгож, амжилттай арилжаа хийхийн тулд системтэй шинжилгээ ба сахилга баттай хандлага зайлшгүй шаардлагатай. Шинэ болон туршлагатай арилжаачдад зориулсан DiNapoli аргачлал зах зээлийн зан байдал, ялангуяа алтны зах зээл хурдтай өөрчлөгдөж буй эдийн засгийн нөхцөлд хэрхэн бэхжиж буйг ойлгоход чухал хэрэгсэл хэвээр байна.

ЕВС Санхүүгийн Группийн оролцоо: Боловсрол ба ил тод байдалд үнэнч үлдэнэ

Энэхүү семинарт оролцсон нь ЕВС Санхүүгийн Группийн арилжааны боловсрол, ил тод байдлыг дэмжих зорилгодоо тууштай байгааг дахин баталсан үйл явдал байв. Дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг, санхүүгийн зах зээлийн судалгаанд тулгуурласан гүн гүнзгий туршлагатай ЕВС салбарын манлайлагчид болон мэргэжлийн

экспертүүдтэй байнга хамтран ажиллаж, Ази болон олон улсын арилжаачдын нийгэмлэгт ач холбогдол бүхий харилцан яриаг бий болгосоор байна.

###

ЕВС Санхүүгийн Группийн Тухай

Лондон хотын санхүүгийн төвд үүсгэн байгуулагдсан ЕВС Санхүүгийн Групп хөрөнгө удирдлага, брокерийн үйлчилгээний чиглэлээр олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг. Лондон, Сидней, Хонконг, Сингапур, Кайманы арлууд, Бангкок, Лимассол зэрэг дэлхийн томоохон санхүүгийн төвүүдэд салбартай тус компани хувь хүн болон байгууллагуудад валют, түүхий эд, хувьцаа, индекс зэрэг олон төрлийн санхүүгийн зах зээлд шууд нэвтрэх боломжийг олгодог.

Компанийн бүс нутгийн салбарууд харьяа улсынхаа зохицуулах байгууллагаар зохицуулагддаг бөгөөд ёс зүй, ил тод байдлыг гол зарчим болгож ажилладаг. ЕВС Санхүүгийн Групп (UK) Limited нь Их Британийн Санхүүгийн Үйлчилгээний Хорооны (FCA) харьяанд, ЕВС Санхүүгийн Групп (Cayman) Limited нь Кайманы Арлуудын Санхүүгийн Зохицуулах Газраар (CIMA), харин Австралийн салбарууд нь Австралийн Үнэт Цаас ба Хөрөнгө Оруулалтын Комиссын (ASIC), ЕВС Financial (MU) Ltd Маврикийн Санхүүгийн Үйлчилгээний Хорооны (FSC) зохицуулалтад тус тус хамаардаг.

40 гаруй жилийн туршлага бүхий санхүүгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн ЕВС-ийн баг Плазагийн Гэрээ, 2015 оны Швейцар франкийн хямрал, COVID-19 цар тахлын үеийн зах зээлийн савлагаа зэрэг дэлхийн томоохон эдийн засгийн мөчлөгүүдийг даван туулж ирсэн туршлагатай. Компанийн соёл нь шударга байдал, харилцан хүндлэл, хөрөнгө хамгаалалтыг нэн тэргүүнд тавьж, хөрөнгө оруулагч бүрийн харилцааг онцгой ач холбогдолтойгоор хүлээн авч, хүндэтгэлтэй ханддаг зарчимд тулгуурладаг.

ЕВС Санхүүгийн Групп алдарт FC Barcelona клубын Албан ёсны Гадаад Валютын Түнш

байгууллага бөгөөд Ази, Латин Америк, Ойрхи Дорнод, Африк болон Номхон далайн бүс нутгуудад тусгай чиглэлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. НҮБ-ын Сан болон дэлхийн хамгийн том оролцоонд суурилсан кампанит ажил болох “United to Beat Malaria” хөтөлбөрийн түншлэлийн хүрээнд дэлхийн эрүүл мэндийн санаачлагуудад хувь нэмэр оруулж байна.

Мөн EBC Оксфордын Их Сургуулийн Эдийн Засгийн Тэнхимийн хэрэгжүүлдэг “Эдийн засагчид юу хийдэг вэ?” олон нийтэд зориулсан боловсролын цувралыг дэмжин оролцож, эдийн засгийн ойлголтыг олон нийтэд энгийн,

хүртээмжтэй байдлаар хүргэж, нийгмийн тулгамдсан асуудлуудын талаарх ойлголт, хэлэлцүүлгийг гүнзгийрүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

<https://www.ebc.com/>

Michelle Siow
EBC Financial Group
+ +60 163376040

[email us here](#)

Visit us on social media:

[LinkedIn](#)

[Instagram](#)

[Facebook](#)

[YouTube](#)

[X](#)

[Other](#)

This press release can be viewed online at: <https://www.einpresswire.com/article/814258996>

EIN Presswire's priority is source transparency. We do not allow opaque clients, and our editors try to be careful about weeding out false and misleading content. As a user, if you see something we have missed, please do bring it to our attention. Your help is welcome. EIN Presswire, Everyone's Internet News Presswire™, tries to define some of the boundaries that are reasonable in today's world. Please see our Editorial Guidelines for more information.

© 1995-2025 Newsmatics Inc. All Right Reserved.